

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАНАРТ ТАВИГДАХ ШАЛГУУР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, 18.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуур”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, үйлчилгээний чанар, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

**ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ ТАВИХ ШАЛГУУР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасны дагуу амьдралын итгэл, үнэмшил бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх болон холбогдох байгууллагаас үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээний зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг хянах, үнэлэх, магадлан итгэмжлэхэд энэ шалгуурыг ашиглана.

Хоёр. Нэр томьёо, тодорхойлолт

2.1.Энэхүү шалгуурт орсон нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. “Сургалт зохион байгуулах үйлчилгээ” гэж зорилтот бүлгийн иргэдэд мэдлэг, чадвар, амьдралын зөв дадал төлөвшүүлэх, хөгжүүлэх чиглэлээр үзүүлэх сургалтыг;

2.1.2. “Амьдралын итгэл үнэмшил бий болгох, бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх сургалт” гэж өөртөө итгэх итгэл, амьдралын зорилго, утга учир, үнэ цэнэ, итгэл үнэмшлийг бий болгох, алсын хараа, мөрөөдөлтэй амьдарч, хариуцлагатай болох, ирээдүйгээ зөв төлөвлөж, зохион байгуулж сурах, аж ахуй, бизнес эрхлэх үндсэн мэдлэг эзэмшүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг;

2.1.3. “Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих сургалт” гэж ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжил, авьяас, чадварыг нь хөгжүүлж, дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг;

2.1.4. “Үйлчилгээг үзүүлэгч” гэж эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсан, сонгон шалгаруулалтад тэнцэн гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг;

2.1.5. “Үйлчлүүлэгч” гэж нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан өрх, иргэнийг.

Гурав. Сургалт зохион байгуулах үйлчилгээний чиглэл

3.1. Амьдралын итгэл үнэмшил бий болгох, бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах. Үүнд:

3.1.1. сэтгэл гутрал, стресст өртсөн үйлчлүүлэгчид амьдралын итгэл үнэмшил олгох, стресс бухимдлаас гарахад дэмжлэг үзүүлэх, аливаа төрлийн донтолтын хор уршгийн талаар сургалт зохион байгуулах;

3.1.2. амьдралын стрессийг даван туулах чадварыг бий болгох зорилгоор гэр бүл төлөвлөлт, хүчирхийллийн болзошгүй эрсдэлт нөхцөлийн талаар болон сэтгэлзүйн боловсрол олгох сургалт зохион байгуулах;

3.1.3. эерэг сэтгэлгээг хөгжүүлэх, өөдрөг хандлага ба амьдралыг үзэх үзэл, мэргэжлийн үнэлэмжээ дээшлүүлэх, харилцаа хандлага, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;

3.1.4. ажил, амьдралын арвин туршлагатай хүний туршлага, мэдлэгийг хуваалцах уулзалт, ярилцлага зохион байгуулах.

3.2. Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах. Үүнд:

3.2.1. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажиллах, хөдөлмөрлөх дадал зуршил бий болгох, авьяасыг нь дэмжихэд чиглэсэн мэдлэг, чадвар олгох чиглэлээр сургалт зохион байгуулах;

3.2.2. гар урлал, сүлжмэл эдлэл, модон эдлэл, бэлэг дурсгал, оёдол, компьютерийн хэрэглээний болон цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт зохион байгуулах;

3.2.3. санхүүгийн болон бизнес эрхлэх суурь мэдлэг олгох, хуримтлал үүсгэх, өрхийн төсөв хөтөлж сурахад чиглэсэн сургалт зохион байгуулах.

3.2.4. мэргэжлийн туршлагатай, ур чадвартай хүний туршлага, мэдлэгийг хуваалцах уулзалт, ярилцлага зохион байгуулах;

Дөрөв. Сургалт зохион байгуулах байгууллагад тавих шаардлага

4.1. Үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1. хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх;

4.1.2. нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас үйлчилгээ явуулах магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсан байх;

4.1.3. өөрийн өмчийн болон түрээсийн байртай байх;

4.1.4. үйлчилгээ үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх;

4.1.5. мэргэжлийн тусгай боловсон хүчинтэй байх;

4.1.6. ажилтнуудын ажил үүргийн хуваарь тодорхой байх;

- 4.1.7. ажилтнуудыг чадавхжуулах төлөвлөгөө, ёс зүйн дүрэмтэй байх;
- 4.1.8. байгууллагын зорилго, зорилт, бүтэц, ажилтны талаарх мэдээлэл болон сургалт зохион байгуулах үйлчилгээний нэр, төрөл, зорилго, хүрэх хэлбэрийн талаар мэдээллийг нээлттэй байршуулсан байх;
- 4.1.9. сургалтын хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөтэй байх;
- 4.1.10. сургалтын чиглэлээр холбогдох дүрэм, журам, ном, сурах бичиг, гарын авлага болон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын талаарх лавлагаа, мэдээллийн сантай байх;
- 4.1.11. сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, дадлагын материалтай байх;
- 4.1.12. эрх бүхий байгууллагаас боловсруулж баталсан сургалт зохион байгуулах үйлчилгээний үр дүн, үр нөлөөг үнэлэх маягт, зааврыг мөрдөх;
- 4.1.13. үйлчлүүлэгчийн талаар түүний зөвшөөрөлгүйгээр мэдээлэл, нийтлэл тараахгүй байх;
- 4.1.14. үйлчлүүлэгчийн гэрийн хаяг, утасны дугаар болон дэлгэрэнгүй бүртгэл, мэдээлэлтэй байх;
- 4.1.15. байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарь дэлгэрэнгүй байх;
- 4.1.16. улс төрийн аль нэгэн нам эвсэл, шашныг сурталчилсан нөхцөл байдал бүрдүүлэхгүй байх;
- 4.1.17. архи, мансууруулах бодис тогтмол хэрэглэдэг, гаж зуршилтай, сэтгэцийн болон халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх.

Тав. Сургалт зохион байгуулах ажилтанд тавих шаардлага

- 5.1. Сургалт зохион байгуулах үйлчилгээний хөтөлбөрт үйл ажиллагааны үндсэн зорилгыг биелүүлэх, зохион байгуулах чадвартай удирдах албан тушаалтан болон сургагч багш, ажилтантай байна.
- 5.2. Тухайн сургалт зохион байгуулах чиглэлийн диплом, үйлчилгээ үзүүлэх эрхийн гэрчилгээтэй байх.
- 5.3. Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.
- 5.4. Үйлчлүүлэгчийн мэргэжил, хөгжил төлөвшил, сургалтын ажлын үр дүнг оновчтой, бодитой тодорхойлон тухайн нөхцөл, орчин, нөөцөд тулгуурлан тодорхой үр дүнд хүрэх, сургалтын үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөдөг, үр ашигтай зохион байгуулдаг, манлайлан удирддаг, тогтмол хянан сайжруулдаг зэрэг сургалтын менежерийн үндсэн чадваруудыг эзэмшсэн байх.
- 5.5. Сургалтад шинэ арга технологийг нэвтрүүлэн бүтээлч шинэ санаа, санаачилга дэвшүүлэн ажил үүргийг чанартай гүйцэтгэж, үйл ажиллагаандаа бүтээлч хандах, ажил хэрэгч чанарыг эзэмшсэн байх.
- 5.6. Үйлчлүүлэгч, суралцагчдыг дэмжин тэднийг хүндэтгэж, эрхийг нь дээдэлдэг байх.
- 5.7. Үйлчлүүлэгчтэй харилцан зөвшилцөж чаддаг, тэдний зан үйлд нөлөөлөх

сурган хүмүүжүүлэх ур чадварыг эзэмшсэн, харилцааны соёлтой байх.

5.8. Мэдээллийн технологийн шинэ ололт амжилтыг эрэлхийлэн, үйлчлүүлэгчдийн эрэлт, тэдний онцлог хэрэгцээнд тохируулан практикт хэрэгжүүлэх талаар бүтээлчээр сэтгэж ажилладаг байх.

5.9. Үйлчлүүлэгчдийн нөөц бололцоог бүрэн дүүрэн илрүүлж, өөрийн нь давуу талыг нь мэдрүүлж, суралцах, өөрийгөө удирдах, хөгжүүлэх талаарх аргыг заан сургадаг байх.

5.10. Сургалт зохион байгуулсан үр дүнгийн тэмдэглэл хөтлөх.

5.11. Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалт хийх чиглэлийн эрх бүхий байгууллагын сургалтад жилд нэгээс доошгүй удаа хамрагдсан байх.

5.12. Ажилтан бүр ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байна.

5.13. Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжийг баримтлан ёс зүйтэй ажиллана.

Зургаа. Сургалт зохион байгуулах үйлчилгээнд тавих шаардлага

6.1. Үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэн, хувийн шинж чанарыг хүндэтгэн үзэж, ялгаварлан гадуурхахгүй байх;

6.2. Сургалтын зорилго, агуулга, арга зүй нь үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн, ажил, мэргэжлийн онцлог хувь хүний хөгжилд дэмжлэг үзүүлэхүйц агуулгатай байх;

6.3. Сургалт зохион байгуулах анги танхим, техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт сургалтын орчинг бүрдүүлсэн байх;

6.4. Үйлчлүүлэгчдэд сургалтын хөтөлбөр, аргачлал, холбогдох журмыг танилцуулах, нөхцөл байдлын үнэлгээ хийн, төлөвлөгөө боловсруулан, хэрхэн тусалж болох талаар мэдээлэл өгч ажиллах;

6.5. Сургалтад хамрагдсан иргэдийн мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх үнэлгээтэй байх;

6.6. Үйлчлүүлэгчдээс сургалтын өмнө болон дараа мэдлэг чадварыг тогтоосон сорил, сургалтын дараах сэтгэл ханамжийн судалгаа авсан байх;

6.7. Сургалтад хамрагдсан үйлчлүүлэгчид үзүүлсэн үйчилгээний явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх, холбогдох мэдлээллийг мэдээллийн санд нэгтгэн оруулах, тайлан мэдээ гаргах;

6.8. Үйлчлүүлэгчийн санал хүсэлт, шаардлагыг хангах, эрэлт хэрэгцээг үнэлэх сэтгэл ханамжийн судалгаа, аргачлалтай байх;

6.9. Хууль, журамд заагаагүй болон гэрээнд тусгагдаагүй ажил үйлчилгээг үзүүлэхгүй байх.

Долоо. Ажлын байр, орчны эрүүл ахуйн шаардлага

7.1. Хот, сууринд байгаа бол төвийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамжинд холбогдсон, цахим харилцаа холбоотой байх;

7.2. Сургалт зохион байгуулах өрөө нь гэгээлэг дулаан уур амьсгал бүхий өнгө будагтай өрөө тасалгаатай, бусад шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж бүхий орчинг бүрдүүлсэн байна;

7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд тохирсон ээлтэй орчинг бүрдүүлсэн байна;

7.4. Хүний амь нас, аюулгүй байдлыг хангах, ахуйн осол, гэмтэл, аюул учруулж болохуйц эд зүйлсийн тухай жагсаалт, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан байна;

7.5. Байгалийн гамшиг болон онцгой байдлын үед ажиллах яаралтай тусламжийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй, түүний дагуу ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна;

7.6. Галын аюулгүй байдлын самбартай, гал унтраах хэрэгслээр хангагдсан байна.

Найм. Сургалт зохион байгуулах үйлчилгээг үнэлэх

8.1. Үйлчилгээг дараахь үзүүлэлтүүдээр үнэлнэ.

8.1.1. үйлчлүүлэгчийн гарын үсэг зурж баталгаажуулсан өдөр тутмын ирцийн тэмдэглэл, зурагт тайлан;

8.1.2. үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, давтамж, сэтгэл ханамжийн судалгааны дүн, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

8.1.3. сургалтад хамрагдсан иргэдийн амьдралын чанарт гарсан өөрчлөлтийн талаар үнэлгээ хийж, эрх бүхий байгууллагад баримт бичиг, мэдээллийг танилцуулан тайланд хавсаргасан байна.

Ес. Бусад

9.1. Энэхүү шалгуурын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан хяналт тавьж ажиллана;

9.2. Үйлчилгээ үзүүлэгч нь тайлан мэдээг худал гаргах, хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэргээр тайлагнасан тохиолдолд гэрээг цуцлах, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.